

**ӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ
/2022 оны 3 дугаар улирал/**

2022.09.22

Өвт

№	Ажлын чиглэл	Үзүүлэлт		Сум, байгууллага /тоон үзүүлэлт/
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо		15632
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо		350
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл, заалтын тоо		16/36
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	150
			Байгууллага	6
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	20
Байгууллага	5			
2	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж /гарсан захирамж/		А захирамж 153, Б захирамж 20 нийт 173 шийдвэр гарсан.
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	-
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	-
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг		15
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо		500
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа		45
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал		4000ш
		Радио, телевизийн нэвтрүүлэг		-
		Сонин хэвлэлээр сурталчилсан		-
		Бусад /		

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

МЭДЭЭ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС
/2022 оны 3 дугаар улирал/**

2022 оны 09 дүгээр сарын 22

Өвт

Бат-Өлзий сумын Эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг зохион байгуулж, Монгол Улсын хууль тогтоомж, хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн хуулийн шторк нэвтрүүлэг зэргийг Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар нийтэлж, олон хүнтэй пэйж, г рүппрүү пост түгээн ажиллаж байна.

Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хуулийн холбогдох заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Нийгмийн хамгааллын хууль тогтоомж, Цэргийн албаны тухай хууль, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн шторк, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Хүүхдээ дэлгэцийн хамаарлаас сэргийлье”, “Бага насны хүүхдүүдийг болзошгүй эрсдлээс хамтдаа хамгаалъя”, “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, шийтгэх гэж юу” видео, “Өсвөр насны охидыг үл хайхрахгүй байх, хараа хяналтыг сайжруулах” зөвлөмж, “4 настнууд юу хийх вэ?”, 5-9 насны хүүхдийнхээ санаа бодлыг сонсох”, “Хүүхдийн эрхийг хэн хангах вэ?” зөвлөмж, зөвлөгөө, шторк зэргийг тогтмол хүргэсэн.

ӨВ. Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч
Sep 16 · 🌐


<https://e-mongolia.mn/home>



ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ
www.e-mongolia.mn
e-mongolia.mn
Цахим үйлчилгээний нэгдсэн портал

ӨВ. Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч
Sep 21 · 🌐

<https://legalinfo.mn/mn>



ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ
legalinfo.mn
Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

ӨВ. Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч
Jun 10 · 🌐

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗААЛТААС.....
24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэсэн, 1.Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тусгай ажил хийлгэж, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хягаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:
2.1 байнга тогтвортой;
2.2 бүлэглэж;
2.3 улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд;
2.4 төрийн албан хаагч үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хягаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж, хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

ӨВ. Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч
Jun 30 · 🌐

Хууль таниулан сурталчилах аян эхэллээ.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИАС.....
🇲🇶 Арван долдугаар зүйл.
1.Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараахь үндсэн үүргийг ёсчлон биелүүлнэ:
1️⃣ 1/Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх;
2️⃣ 2/хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;
3️⃣ 3/хуулиар ногдуулсан албан татвар төлөх;
4️⃣ 4/эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах.

2.Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн. 1️⃣

ӨВ. Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч
Sep 21 · 🌐

ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ
Цэргийн албаны тухай хууль
Хуулийг бүрэн эхээр дараах холбоосоо үзээрэй.
Холбоос:
https://legalinfo.mn/mn/detail/12124?fbclid=IwAR0_HpC_U0c3Q2GvcFfABC5Hy_J... See more



ӨВ. Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч
Sep 8 · 🌐

АЖИЛГҮЙДИЙН ТЭТГЭМЖ АВАХ ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Ажилгүйдлийн тэтгэмж авах хуулийн зохицуулалт



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар тогтоолоор баталсан “Иргэдийн аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэхэд баримтлах журам”-ын хэрэгжилтийг хангуулж, 2022 оны 07 дугаар сард сумын Татварын байцаагч, Хүнс, жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн, Байгаль хамгаалагч, газрын даамал хамтран сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж

буй эко гэр, баазуудаар явж журамд орсон нэмэлт өөрчлөлтийн заалт бүрийг танилцуулан, халдвар, хамгааллын дэглэм сахиулан иргэдийн гэрийн ариун цэвэр, үйлчилгээний стандартыг сайжруулсан. Сурталчилгаанд аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч 100 гаруй иргэн хамрагдсан.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан төр, хоршооллын хамтын ажиллагааг өргөжүүлэх, төрөөс хоршооны талаар баримталж буй бодлого, арга хэмжээг сурталчлах, хоршоодыг идэвхжүүлэх зорилгоор 2022 оны 07 дугаар сарын 20-нд суманд "Хоршооны үзүүлэх сургууль"-ийг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд сумдын Засаг дарга, хоршоо хариуцсан мэргэжилтэн, хоршоологчдын төлөөлөл нийт 16 сумын 90 гаруй хүн хамрагдав.

Тус үзүүлэх сургуулиар:

- Аймгийн Хоршооны салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал,
- Хоршооны тухай хуулийн хэрэгжилт, хоршоог дэмжих талаар Бат-Өлзий сумын ИТХурлаас баримталж буй бодлого,
- Бат-Өлзий сумын хоршоодын өнөөгийн байдал, цаашдын хамтын ажиллагаа,
- Өвөрхангай аймагт үржүүлэгдэж буй үүлдэр омгийн мал ашиг шим, малын зах зээлийн үнэлэмж,
- Ноос, арьс ширний анхан шатны тордолт, Хоршоог шинэчилсэн бүртгэлд хамруулахад анхаарах асуудал,
- Малчдын хамтын хүч хоршооны танилцуулга,
- ХХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэхэд анхаарах асуудал зэрэг сэдвээр илтгэл, мэдээлэл хийж, Хоршоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн гаргав. Мөн Улсын тэргүүний "Малчдын хамтын хүч" хоршооны Нэхийний цех, "Нэг сум нэгдсэн мал эмнэлэг" малчдын байгууллагын төв, "Витафит милк" ХХК-ийн үйл ажиллагаатай тус тус танилцаж туршлага судалсан.



Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн тасаг хамтран үер усны аюулаас болгоомжлох анхааруулга самбарыг Өвтийн гол, Улаан цутгалан, Төвхөн, Орхон гол, Цагаан гол гэсэн 5 байршилд байршуулж, 500 гаруй иргэнд мэдээлэл өгсөн.

Хууль бус ан агнуурын хор уршиг, хууль, эрх зүйн мэдээллийг Бат-Өлзий сумын цахим хуудсаар мэдээлсэн. Мэдээ, мэдээлэлд 5000 гаруй иргэнд хүрсэн.

Түймрийн аюултай үеүүдэд ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэдэд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цахимаар болон цаасаар хүргэж, сурталчилсан. Сурталчилгаанд 3000 гаруй иргэн хамрагдсан. Мөн хөдөөгийн багийн 350 айл өрхөд ой, тал хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, асаасан гал, нурам, цогоо бүрэн унтрааж байх санамж бичиг, сэрэмжлүүлэгийг хийж тараасан.

Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд албан хаагчдынхаа дунд “Хүүхэд хамгааллын бодлого” сургалтыг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Сургалтанд 100 гаруй албан хаагч хамрагдсан.

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан эрүүл мэндийн сургалт, мэдээллийг тухай бүр зохион байгуулсан. Тайлант хугацаанд цахим хуудсаар дамжуулан иргэдэд 15 удаагийн сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээлэл байршуулсан ба хандалтын тоо 7523-д хүрсэн. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд нийт 500 ширхэг зөвлөмж хийж, тараасан.

2022 оны 3 дугаар улиралд эрх, зүйн сургалт, сурталчилгааг 15 удаа явуулж, 20 сэдвээр 4000 гаруй зөвлөмж, гарын авлага, тараах материал иргэдэд тарааж ажилласан байна.

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

